

Жагарын оронд Ри багштайгаа өнгөрүүлсэн өдрүүдийн тухай дурсамжаас

Д.Төмөртогоо

Миний бие 1964 онд монгол дөрвөлжин үсэгийн нэгэн өвөрмөц бичлэгийн тухай анхныхаа үгүүлэлийг тэрлэн бичээд их эрдэмтэн академич Ринчен багшид хэд хэдэн удаа үзүүлэн, зааж зөвөлсөнийх нь дагуу дахин дахин засч бичсээр 1965 оны хавар түүний гарын үсэг бүхий зөвшөөрөлийн бичигийг гардан авч билээ. Тийнхүү зөвшөөрөл авсаны учир нь гэвэл, тэр үед залуу судлаачидын бүтээлийг академич хүний зөвшөөрөлөөр хэвлэдэг журамтай байсан бөгөөд тэр нь шинэ залуу эрдэмтэдийн бүтээлийн чанарыг сайжируулж, төвшинг дээшилүүлэхэд ихээхэн түлхэц болсон гэж боддог. Дэлхийд алдартай тэр их эрдэмтэний эх барьж авсан анхны маань үгүүлэл нэг жилийн дараа "Монголын судлал" хэмээх нэр хүндтэй сэтгүүлийн 1966 оны 4-р ботид академич Ш. Лувсанвандан, унгарын эрдэмтэн Лайош Бэшэ зэрэг том эрдэмтэдийн бүтээлтэй хамт хэвлэгдсэн нь надад урам хайрлаж, цаашидын минь эрдэм шинжилгээний ажилын эхлэл нь болсон билээ.

Ринчен багштай энэ мэтээр уулзаж ярилцсан минь цөөнгүй боловч тэр бүхэний тухай олоныг үл үгүүлэн, харийн нутаг, Жагарын оронд хамт өнгөрүүлсэн мартагдашгүй дурасхалт өдөрүүдийнхээ тухай энд товч үгүүлэе.

Одоогоос гучин гурван жилийн өмнө Энэдхэгийн нийслэл Шинэ Дели хотноо болсон олон улсын санскрит судлаачидын анхдугаар их хуралд миний бие Ринчен багшийн хамт оролцож, нэгэн долоо хоногийг хамт өнгөрүүлж билээ. Тэр үед би Ж. Неругийн нэрэмжит их сургуулийн Төв Ази-Хималайн судлалын төвд монгол судлалын багшаар томилогдон очоод төдий л удаагүй байлаа.

1972 оны 3-р сарын 24-ний нарлаг сайхан өдөр Шинэ Дели хотын нисэх буудалаас Ри багшаа тосч аваад, Гольф линк хэмээх тансаг хороололд байх элчин сайдынхаа яаман дээр хүрч ирэхэд элчин сайд Дэמידдагва найрсаг сайханаар хүлээн авч, өдөрийн зоог барилаа. Орой нь бид хоёр хуралын төлөөлөгчидийн байрлах Акбар хэмээх тансаг буудалд шилжин орлоо. Их Моголын эзэн хааны нэрээр нэрлэсэн тэр буудал өрнө дахины бадируун хийц, дорнодахины нарийн урлалыг чадамгай хосолсоноороо нэн гоёмсог байлаа.

Ринчен багшийг очсоны маргааш өглөө нь Дели хотын төвд байх "Эрдэмийн ордон" хэмээх олон улсын хуралын байранд Санскрит судлалын анхдугаар их хурал ёслол төгөлдөр эхэлж, энэдхэгийн ерөнхийлөгч Гири хуралыг нээж үг хэллээ. Их хуралын нээлтийн ёслол дээр энэдхэгийн мэдээлэл-аялал жуулчилалын сайд Каран Сингх, Балбын нийслэл Катмандугаас ирсэн 8 настай хүү хоёр эртний энэдхэгийн яруу найрагаас санскрит хэлээр уншсаныг багш маань анхааран сонсох зуураа түүнийг Төв Азийн алдарт туульстай зүйрлэн, бидэнд ч үүнээс дутахгүй их өв бий шүү хэмээн бахархаж байв. Ринчен багш бараг л юм бүхэнийг монголтойгоо холбож, монголоос гаралтай гэнэ. Нэг удаа Гаалидасын "Үүлэн зардас" хэмээх алдарт зохиолоор найруулсан бүжигийн концерт үзэж суугаад: "Энэ чинь манай баруун монголын бүжигийн хөдөлгөөнөөс авчихсан байна" гэж байж билээ.

Хуралын эхний завсарлагаанаар багштай хамт ордоны урд үүдээр гарч ирэхэд хуралд оролцож байгаа улсуудын тугийг үүдний хоёр талаар мандуулсан байв. Орох үүдний зүүн гар талаар эгнүүлэн байрлуулсан далбаануудын дунд байгаа соёмбот далбаагаа хараад багшийн маань сэтгэл ихэд хөдлөн: "Жагарын тэнгэрт улсынхаа далбааг та бид хоёр л мандуулж байгаа

юм шүү дээ” гэж хэлэхэд нь би сая л санаа авч, төрийнхөө далбааны дэргэд багшийнхаа зурагийг авахаар аппаратаа гарган шагайлаа. Гадаа огтхон ч салхигүй намуун сайхан байсан тул би туг хийсч, соёмбо тэмдэг гарахыг удтал хүлээн аппаратаа шагайсаар л, багш маань ч ганайтал зогссоор л байлаа. Үл мэдэгхэн салхи хөдөлж, тугныхаа соёмбыг дөнгөж ил гарах тэрхэн агшинд арайхийн амжиж авсан ганцхан хувь тэр зураг одоо надад бий.

Хуралын чөлөөгөөр олон ороны эрдэмтэд бие биетэйгээ уулзан, чөлөөтэй ярилцана. Тэр олон төлөөлөгчидийн дунд хүрэн торгон дээлэн дээрээ мөнгөн тоногтой өргөн суран бүс бүсэлж, урт буурал үс нь захаа даван унжсан дорнодахины омог бардам царайтай нэгэн хүн онцгой содон харагдаж, сурвалжилагчийн хараанд бүхэнээс түрүүнд өртөнө. Нэг удаа бид хоёрыг хамт зогсож байтал нимгэн ёрог даавуун хувцастай энэдхэг эр хүрч ирээд, өөрийгөө “Статисмэн” сонины сурвалжилагч хэмээн танилцуулаад, Ринчен багшаас ойр зуурын хоёр гурван зүйл лавлаж асуусанаа багшийн маань өмссөн намбалаг сайхан дээл хувцасыг ажиглан хараад: “Миний биенд байгаа бүх хувцас гуравхан рупийн үнэтэй, таны өмссөн хувцас хэдэн рупийн үнэтэй вэ?” гээд асуучихлаа. Би түүний асуултыг дамжуулан хэлтэл тэрвээр өчүүхэн ч бодож түгдэрэлгүйгээр: “Ядуу зүдүүгийн зовлон үзэж яваагүй болохоор өмөсч байгаа хувцасныхаа үнийг өдий хүртэл бодож үзээгүй юм байна гээд унгахих” гээд хэнэггүйхэн хэлчихэж билээ. Багшийнхаа шуудхан хэлчихсэн ганцхан үгүүлбэрийг дамжуулж хэлнэ гэдэг надад харин тун ярвигтай байж билээ. Саваагүйхэн асуултандаа гашуухан хариулт авсан тэр сурвалжилагч урамгүйхэн цааш эргэх зуур өөр нэгэн сурвалжилагч хүрч ирээд Ри багшийн энгэр дээр байсан одонгийн лентүүдийг их л сонирхон харсанаа: “Таны энгэр дээр байгаа энэ алаг шилнүүд ямар учиртай юм бэ?” хэмээн асуухад тэрвээр одонг төлөөлдөг юм гэж товчхон хариуллаа. Тэгтэл нөгөө сурвалжилагч сониуч зангаараа “Та дэлхийн хоёрдугаар дайнд оролцсоны учир эдгээр одонгоор шагнуулсан юм уу” гэсэн гэнэхэн асуулт тавихад: “Би дайны талбарт хүний цус урсгаж яваагүй, харин үндэстэнийхээ соёлыг хөгжүүлэхэд хөлөсөө асхаруулж явсан юм” гэсэн хатуухан үгээр хариу барьж билээ.

Бид хоёр олон салбар хуралдаануудаас их төлөв “Санскрит хэл, соёл” гэсэн салбар хуралдаанд сууж байлаа. Хуралын гуравдахь өдөр багш маань “Бодичария-аватаргаас уламжилалтай монгол дуу”, би “XIII-XIV зууны монгол бичигийн хэлэнд орсон санскрит үгс” гэсэн илтгэл тавьж, хуралд оролцогчид анхааралтай хүлээж авлаа. Ялангуяа Ринчен багш илтгэлийнхээ дараа эртний уламжилалт монгол дууны жишээ болгон ардын хоёр дууны бичлэг сонгосон нь хуралдаанд оролцогчид онцгой таалагдаж, нэг ёсны амаралт, завсарлага болж билээ.

Хуралын хоёрдох өдөр Хайдарбад ордоны задгай цэцэрлэгт болсон үдийн зоог дээр ерөнхий сайд, хатагтай Индира Ганди хүрэлцэн ирж, тусхайлан зассан урт ширээний ард бараа бологчидынхоо хамт суулаа. Тэрвээр хуралын төлөөлөгчидэд баяр хүргэж үг хэлсэний дараа хурал зохион байгуулагчид болон гадаадын зарим төлөөлөгчид хатагтай Индира Гандид баяр хүргэж үг хэллээ. Тэгэж байтал багш маань гэнэт босоод намбатайхан алхсаар урт ширээний өнцөгт хүрч, нэг хүнтэй уулзан хэдэн үг солилцоод, уламаар тэр хүн багшийг дагуулан явсаар хатагтай Индира Гандийн дэргэд хүргэж өглөө. Багш маань ерөнхий сайдын зүүн гар талд суугаад үе үе гараа дохин ярилцаж байх нь харагдлаа. Би хажуудаа суусан хүнтэй энэ тэрийг ярилцан сууж байтал гэнэт мөрөн дээр нэг хүн хүчтэй нь аргагүй алгадаад авлаа. Эргэн хартал багш маань их л сэтгэл хөдөлсөн шинжтэй, баясхалантайгаар инээмсэглэн, гартаа барьсан тэмдэглэлийн дэвтэрээ надад өглөө. Дэвтэрийг нээн үзвэл Индира Ганди хатагтай ерөөлийн үг бичиж, гарын үсгээ зураад эцэст нь 1972 оны 3-р сарын 28 хэмээн бичсэн байв. Ринчен багш 1958 онд Энэдхэгт анх айлчилахдаа Индира Ганди-ийн эцэг, Энэдхэгийн анхны ерөнхий сайд асан Жавахарлал Нерутэй нүүр учиран уулзаж, энэдхэг-монголын соёлын харилцааны уламжилалын талаар ярилцаж байсанаа надад дурсан яриж билээ. Үдийн зоог-ярилцлагын дараа хуралд оролцогчид ерөнхий сайд Индира Гандитай хамт зурагаа авахуулсан минь эдүгээ мартагдашгүй үнэтэй дурасхал болон хадгалагдаж байдаг юм.

Оройн хоолны дараа буудалдаа ирээд хоёул тус тусынхаа өрөөнд сууж, маргааш тавигдах илтгэлүүдийн хураангуйтай танилцаж байтал үүдний хонх дуугарлаа. Очоод үүдээ тайлж өгтөл лам дээлтэй гурван монгол хүн урт цагаан хадаг барин амар мэнд мэдээд: “Бид Ринчен докторт бараалхахаар ирлээ, Хаана саатаж байна?” хэмээв. Багшийн өрөөнд тэднийг дагуулан ороход тэд хадаг сэлт өргөн бариад, бараг хоёр цаг хөөрөлдөв. Гэнэт орж ирсэн


тэдгээр зочид бол эдүгээ монголчууд бидний сайн танил, монголын бурханы шашиныг сэргээн хөгжүүлэхэд өглөг буянаа хайрласан их ламтан Гүрүдива ринбүчий, түүний төвөд шавь, мөн гучаад оны үед ар монголоос гарч Балба газар олон жил суусан Равсал хэмээх лам эд гурав байлаа. Гүрүдива лам 43 жилийн тэртээ анх нутагаасаа гарсанаас хойш өдий хүртэл хаагуур хаагуур явж, юу юу хийж явсан тухайгаа хуучилсан нь үнэхээр сонин байлаа. Хоёр цаг үргэлжилсэн сонин сайхан яриа түр завсарлаж, цай уухын зуур эх нутагаа санагалзсан хоёр ламтандаа нутагаасаа авчирсан ардын дууныхаа бичлэгийг сонгосонд гойд их сонирхож байлаа. Цай идээний дундуур Гүрүдива ринбүчий Жагарын оронд амьдаран суудаг монголчуудын тухай сонин сайхан яриа дэлгэж, бид хоёр ч чих тавин сонслоо. Нэг л мэдэхэд шөнийн 11 цаг болчихсон байв. Харин бидний ярианд оролцоогүй байсан нөгөө өвгөн лам Равсал гуай маань ардын дуу эгшиглэсэн магнитофоны нүүрэнд чихээ наалдуулчихсан, өмөссөн дээлийнх нь энгэр дээгүүр уяралын нулмис зам татуулан урссан байхыг хараад хэлэх ч үг олодохгүй, өөрийн эрхгүй өрөвдөх сэтгэл төрж, хамарын самсаа шархирах шиг болж билээ. Ринчен багш бид хоёр тэднийг гарсаны дараа Равсал ламаар жишээ аван эх орон гэдэг ямар үнэтэй, ямар эрхэм болох тухай удтал ярилцаж билээ. Ер хүн гэдэг амьтан эх ороныхоо үнэ цэнийг харин нутагт байхадаа л илүү их мэдэрдэг юм билээ.

Бүтэн таван өдөр амжилттай сайхан чуулсан хурал маань өндөрлөж, хуралд ирсэн гадаадын төлөөлөгчидийг эртний түүхт Агра хот, алдарт Таж Махалын бунхан, Их Моголын хаадын хэрэм цайз, дундад энэдхэгийн Жанси, Гвайлор зэрэг түүх дурасгалын газаруудаар гурван хоног аялуулах боллоо. Харин багш маань ардаа ажил ихтэй тул маргааш буцна гэлээ. "Тэр холоос нэгэнт ирсэнийх, эртний энэдхэгийн түүх дурасгалын алдартай газаруудаар гуравхан хоног яваад үзвэл дээр биш үү" хэмээн ядхан гуйхад минь "Орчилонгийн аль сайханыг нэгэн биеэр үзэж барахав дээ" хэмээн өөдөөс минь сургачихаад тэрхүү сонин сайхан аялалд явалгүй, нутагийн зүг яаран буцаж билээ.

Тийнхүү Жагарын тэнгэр дор их багштаныхаа үзэж харсан, дуулж сонссон сонин сайханаас нь яриулж, далай их эрдэмийг нь биширч өнгөрөөсөн бүтэн долоо хоног нүд ирмэхийн зуур харван өнгөрч билээ.



Энэтхэгийн ерөнхий сайдын хүлээн авалтын үеэр



Олон Улсын Санскрит судлалын анхдугаар их хуралын үеэр.
Энэтхэгийн ерөнхий сайд Индира Ганди, академич Б. Ринчен нар
болон хуралд оролцсон зарим эрдэмтэдийн хамт. Шинэ Дели. 1972.



Энэтхэгийн "Эрдэмийн Ордон"-ы үүдэнд төрийнхөө далбааны өлмийд
багштаныгаа зурагийг авсан минь. Шинэ Дели. 1972.03.29.